



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах
эрхийг хэрэгжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь заалт, 54 дүгээр зүйлийн 54.3, 54.4, 54.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7, 76.1.17 дахь заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Дүрмийн 9.4.6, 9.4.15, 9.4.18 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн Аудитын хорооны 2025 оны 11-р сарын 07-ны өдрийн дүгнэлт болон хараат бус үнэлгээний байгууллага болох Эм Би Ви Си ХХК-ийн үнэлгээний тайлан ("Үнэлгээний тайлан")-г тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчид нь Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 75 (далан таван) буюу түүнээс дээш хувийг эзэмших болсон тул бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн Компанид эзэмшиж буй энгийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх ("Шаардах эрх")-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Ийнхүү Шаардах эрхийг хэрэгжүүлэхдээ энэхүү тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авалт хийхийг Компанийн хувьцаа эзэмшигч Премиум Коммерс ХХК-аар хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн хувьцааны сүүлийн 6 (зургаан) сарын жигнэсэн дундаж ханш нь 199.76 (нэг зуун ерэн ес зууны далан зургаан) төгрөг байгааг дурдсугай.
4. Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж энгийн хувьцааны үнийг 350 (гурван зуун тавин) төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэсүгэй.
5. Шаардах эрхийн дагуу шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 11-р сарын 07-ны өдрөөр тогтсугай.
6. Шаардах эрхийг хэрэгжүүлэх журам, хэрэгжүүлэх үнэ, хугацааг тусгасан ("Журам")-ыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Шаардах эрхийн тухай мэдэгдлийг 2025 оны 11-р сарын 07-ны өдөр биржийн арилжаа хаагдсаны дараа Монголын Хөрөнгийн Бирж ХК, Компанийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
8. Шаардах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал болон Премиум Коммерс ХХК-ийн Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.
9. Шаардах эрхийг хэрэгжүүлэх мэдэгдлийг 2025 оны 11-р сарын 07-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д бичгээр хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

Шийдвэр гаргасан он сар өдөр, цаг:

2025 оны 11-р сарын 07-ны өдрийн 14:00 цаг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА (ХАРААТ БУС):



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:




А.ГАНХУЯГ



А.ГАНБОЛД



Г.БАТ-ЭРДЭНЭ



Ч.МӨНХЧИМЭГ



Г.ЧИНЗОРИГ



Б.БАТ-ЭРДЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Ө.ЭРДЭНЭЧИМЭГ



В.ГАНЗОРИГ



**ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ХУВЬЦААГ
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Премиум Нэксус ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам (цаашид “Журам” гэх)-аар Компанийн нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчид Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаатай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлийн дагуу хувьцаагаа худалдах шаардах эрхээ хэрэгжүүлж буй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани энэхүү Журмын дагуу Компанийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхээ хэрэгжүүлж буй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигч Премиум Коммерс ХХК-д зөвшөөрсөн болно.
- 1.3. Шаардах эрх хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл

Компанийн тухай хуулийн 53.2 дахь заалт: Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

Компанийн тухай хуулийн 54.4 дэх заалт: Хувьцаа эзэмшигч нь түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг худалдан авах, эсхүл хувьчлалын дүнд хувьцааны хяналтын багцыг худалдан авсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах болох талаар төлөөлөн удирдах зөвлөл уг хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор хувьцаа эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.

**ХОЁР. ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ШААРДАХ
ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

- 2.1. Компанийн Нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдийн хувьцаа 75 хувийг давснаар 2025 оны 11-р сарын 07-ны өдөр (“Шаардах эрх үүссэн өдөр”)-ийг хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүссэнд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг уг шаардах эрх үүссэн өдөр Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл (Үнэт цаас эзэмшигчдийн судалгаа)-д байсан мэдээллийг үндэслэн гаргана.
- 2.2. Компани нь хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 дугаар бүхий Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.
- 2.3. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг уг шаардах эрх үүссэн тухай Компаниас албан ёсны мэдэгдэл гаргаснаас хойш ажлын 30 өдрийн дотор энэ Журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу цаасан болон цахим (маягтыг бөглөн сканнердсан хувилбарыг цахимаар илгээх) хүсэлт гаргаж илгээх эсхүл өөрийн бүртгэлтэй үнэт

цаасны компанид хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлт гаргаж, бүртгүүлэх замаар тус тус өөрийн хувьцаагаа худалдах сонирхлоо илэрхийлнэ.

- 2.4. Компани нь хувьцаа эзэмшигч нарт шаардах эрх үүссэн тухай албан ёсны мэдэгдэл гаргаснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирсэн хүсэлтэд үндэслэн худалдан авалт хийж, эрх бүхий байгууллагад хууль, тогтоомжид заасан хугацаанд бүртгүүлж хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 2.5. Хувьцаа эзэмшигч Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтээ өгсөн бол тухайн хүсэлтэд заасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулах аливаа үйлдэл хийхгүй. Хэрэв хувьцаанд ногдох төлбөр хийгдэх үед хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансанд хүсэлтэд дурдсан тоо ширхэг үгүй бол хүсэлт биелэлэгдэхгүй. Үүнтэй холбогдон гарсан хариуцлагыг Хувьцаа эзэмшигч өөрөө хариуцна.
- 2.6. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах хувьцааг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон шаардах эрхээ хэрэгжүүлэх тухай мэдэгдэлд заасан үнийг үндэслэн худалдан авна.
- 2.7. Тогтоосон хугацаанд Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй буюу хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигч нь гомдол гаргах эрхгүй байна.
- 2.8. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдахдаа шаардлагатай мэдээллийг үнэн зөв ирүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь хувьцаа эзэмшигчийн шаардах эрхийг хэрэгжүүлэх гол үндэслэл болно. Хувьцаа эзэмшигч мэдээллээ зөрүүтэй ирүүлснээс үүдэн гарсан үр дагаврыг Компани хариуцахгүй болно.
- 2.9. Компанийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор эргүүлэн худалдаж авах эрхийн тухай мэдээлсэн мэдэгдэлд заасан үнээр хувьцааг худалдан авах, эсхүл хувьцаа эзэмшигчийн хувьцааг эргүүлэн худалдаж авахаас татгалзсан үндэслэлээ хувьцаа эзэмшигчид бичгээр эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 2.10. Энэхүү Журамд заасан хугацаанд багтаан хүсэлтээ ирүүлсэн хувьцаа эзэмшигч нарын шаардлагын дагуу тус хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хувьцааны үнээр тооцож Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн дансанд байршуулна.
- 2.11. Хувьцаа эзэмшигчдэд хүргэх зарын төслийг энэхүү журмын Хавсралт №2-оор баталгаажуулсан болно.

Премиум Нэксус ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын Хавсралт №1

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХЫГ ШААРДАХ ХУУДАС**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрт үүссэн хувьцаа худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа тул Премиум Нэксус ХК-ийн _____ ширхэг энгийн хувьцааг нэгж үнийг 350 төгрөгөөр тооцон, худалдан авахыг зөвшөөрч, хувьцаанд ногдох мөнгийг өөрийн дансанд хүлээн авах шаардлагыг гаргаж байна.

№	Утга	Мэдээлэл
1.	Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:	- Хуулийн этгээд - Иргэн (Тэмдэглэгээг хийнэ үү.)
2.	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр / Хуулийн этгээдийн оноосон нэр:	
3.	Регистрийн дугаар/Иргэний бүртгэлийн дугаар:	
4.	Оршин байгаа газрын хаяг:	
5.	Энгийн хувьцааны тоо ширхэг:	
6.	Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар: (өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниас тодруулна уу)	
7.	Холбоо барих утасны дугаар:	
8.	Цахим шуудан:	

Шаардлага гаргасан:

Он сар өдөр:	
Гарын үсэг:	

Баталгаажуулсан (Компани эсхүл ҮЦК):

Хүсэлт хүлээн авагч:	- Голомт Капитал ҮЦК ХХК - Премиум Нэксус ХК (Тэмдэглэгээг хийнэ үү.)
Хүсэлт хүлээн авсан он сар өдөр:	
Хүлээн авсан ажилтны гарын үсэг:	

Баталгаажуулсан (ҮЦТХТ ХХК):

ҮЦТХТ Хүсэлт хүлээн авсан огноо:	
Хүсэлт хүлээн авсан ҮЦТХТ-ны ажилтан:	
Гүйлгээ хийсэн ҮЦТХТ-ны ажилтан:	
Хянасан ҮЦТХТ-ны дарга:	

Энэхүү шаардах хуудаст хувьцаагаа эргүүлэн худалдах шаардлага гаргаж буй хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргасан байна.

Премиум Нэксус ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж
авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын
Хавсралт №2

ПРЕМИУМ НАКСУС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Премиум Нэксус ХК ("Компани")-ийн нэгдмэл сонирхол бүхий хувьцаа эзэмшигчид Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 75 хувь буюу түүнээс дээш хувийг эзэмших болсон тул Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлийг үндэслэн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэрийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргаж, Премиум Коммерс ХХК-д уг хувьцааг худалдан авах зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Хувьцаа худалдан авах мэдээлэл:

Хувьцаа худалдаж авах нэгж хувьцааны үнэ:	350 (гурван зуун тавин төгрөг)
Шаардах эрх үүссэн өдөр:	2025 оны 11-р сарын 07-ны өдөр
Хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг хүлээн авах хугацаа:	2025 оны 11-р сарын 10-ны өдрөөс 2025 оны 12-р сарын 23-ны өдрийг дуустал
Эргүүлэн худалдах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хувьцааны мөнгөн дүнг байршуулах хугацаа:	2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийг дуустал

Эрхэм хувьцаа эзэмшигч та өөрийн эзэмшиж буй хувьцааг дээрх үнийн дүнгээр эргүүлэн худалдах хүсэлтэй бол өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компанид хандан хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтээ илэрхийлэн зохих ёсны бүртгэлийг хийлгэх эсхүл Голомт капитал ҮЦК ХХК болон Премиум Нэксус ХК ийн халгаар, холбогдох материалуудыг бүрэн бүрдүүлэн илгөөнө үү.

Хүсэлт хүлээн авах суваг №1:

Хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй Үнэт цаасны компанид хувьцаагаа зарах хүсэлт гаргаж, зохих ёсны бүртгэлийг хийлгэнэ.

(Дээрхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны компанидаа хандаж авна уу.)

Хүсэлт хүлээн авах суваг №2:

№	Хүсэлт хүлээн авагч	Цахим хүсэлт хүлээн авах хаяг	Цаасан хүсэлт хүлээн авах хаяг	Холбоо барих дугаар
1	Голомт Капитал ҮЦК ХХК	info@golomtcapital.com	Парк Плэйс оффис, 4 давхар, 403 тоот, Чингисийн өргөн чөлөө-24 хаяг	7012-1530
2	Премиум Нэксус ХК	huvitsaa@cumongol.mn	УБ, БЗД, 26-р хороо, Сакура тауэр, 6 давхар 603 тоот	8687-8020 9000-2550

Бүрдүүлэх материал:

- Премиум Нэксус ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын Хавсралт №1 Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлт
- Хувьцаа эзэмшигч иргэн: Иргэний үнэмлэхийн хуулбар, лавлагаа, итгэмжлэл
- Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэл

Жич: Хувьцаа эзэмшигч Хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагаа дуусах хүртэл хүсэлтэд эсхүл захиалаад заасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулахгүй. Хэрэв компани хувьцааны тоо ширхэгт ногдох мөнгөн дүнэ байршуулахад хүсэлтэд заасан тоо ширхэг хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансанд байхгүй тохиолдолд хүсэлтийг биелүүлэхгүй байх нөхцөл бүрдэх болохыг анхаарна уу.



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг чөлөөлж,
шинээр томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дах заалт, Премиум Нэксус ХК (“Компани”)-ийн Дүрмийн 9.4.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Гүйцэтгэх захирал А.Ганхуягийг 2025 оны 11-р сарын 06-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, 2025 оны 11-р сарын 07-ны өдрөөс эхлэн Компанийн Ерөнхийлөгчөөр томилсугай.
2. Компанийн Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзоригийг 2025 оны 11-р сарын 06-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, 2025 оны 11-р сарын 07-ны өдрөөс эхлэн Компанийн Гүйцэтгэх захирлаар томилсугай.
3. Компанийн Гүйцэтгэх захиралд орсон өөрчлөлтийг холбогдох зохицуулагч, бүртгэгч байгууллагуудад мэдэгдэх, бүртгэл хийлгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Т.Гантулга) болон Бүртгэлийн менежер (Б.Номин-Эрдэнэ) нарт тус бүр даалгасугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА (ХАРААТ БУС):



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:




А.ГАНХУЯГ



А.ГАНБОЛД



Г.БАТ-ЭРДЭНЭ



Ч.МӨНХЧИМЭГ



Г.ЧИНЗОРИГ



Б.БАТ-ЭРДЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Ө.ЭРДЭНЭЧИМЭГ



В.ГАНЗОРИГ